

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-174-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт <i>(Шинэчлэгдэж байгаа)</i> <i>/18 хуудас NZ Part 174-ийн 2017 оны 03 сарын 10-ны А.5-д үндэслэсэн /</i></p>	<p align="center">АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН БАЙГУУЛЛАГА - ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ <i>/10 хуудас Хүчинтэй мөрдөгдөж байгаа2001 он /</i></p>	<p align="center">Тайлбар</p>
<p>А Бүлэг - Ерөнхий зүйл</p>	<p>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>	
<p>174.1. Хамрах хүрээ Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно: (1) нисэхэд цаг уурын үйлчилгээ үзүүлэх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны; (2) нисэхийн цаг агаарын үндсэн мэдээгээр хангах нөхцөлийн.</p>	<p>174.1 <u>Зорилго</u> (а) Иргэний агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд шаардлагатай цаг уурын мэдээний хангалтад тавигдах шаардлагыг тодорхойлох, Нисэхийн цаг уурын үйлчилгээ эрхлэх байгууллагыг гэрчилгээжүүлэхэд энэ дүрмийн зорилго оршино.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>174.3. <u>Нэр томъёо болон товчлол</u> <u>Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</u></p>	<p>174.3 <u>Тодорхойлолт</u></p>	<p>- Нэр томъёоны тайлбар,тодорхойл олтууд ИНД-1-д орсон.</p>
<p>174.5. Гэрчилгээний шаардлага (а) Аливаа этгээд энэ Дүрмийн дагуу олгосон нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын (цаашид “НЦУУБ” гэх) гэрчилгээний эрхийн хүрээ болон нөхцөлд заагаагүй нисэхийн цаг уурын үйлчилгээг үзүүлэхгүй байх үүрэгтэй. (б) <u>Дарга Монгол Улсын агаарын навигацийн системтэй харилцан ажиллах зорилгоор, цаг уурын албаны сүлжээгээр хангагдсан, цаг уурын нэг, эсхүл хэд хэдэн үйлчилгээ үзүүлэх чадвартай байгууллагыг нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрч, гэрчилгээ олгож болно.</u></p>	<p>174.5 Цаг уурын үйлчилгээ <u>үзүүлэх</u> (а) Энэ дүрмийн дагуу гэрчилгээ эзэмшээгүй аливаа этгээд нисэхийн цаг уурын үйлчилгээ эрхлэхгүй. (б) ИНЕГ-ын дарга нь энэ дүрэмд заасан нисэхийн цаг уурын үйлчилгээний аль нэгийг, эсхүл бүгдийг эрхлэх эрхийг олгож болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан - Amend.1-ээр нэмэгдсэн</p>
<p><u>174.6. Цаг агаарын үндсэн мэдээ</u> Цаг агаарын үндсэн мэдээгээр хангадаг этгээд нь дараах шаардлагыг хангасан байна: (1) хийж байгаа ажиглалтад үзлэг шалгалт хийсэн төхөөрөмжийг ашиглах; (2) тухайн төхөөрөмжийг шалгах тогтолцоог хэрэгжүүлэх; (3) үнэн зөв цаг агаарын үндсэн мэдээгээр хангах сургалтад хамрагдсан байх.</p>	<p>174.6 Цаг агаарын <u>байнгын ажиглалт</u> (а) Цаг агаарын байнгын ажиглалт хийж буй этгээд нь: 1/ цаг агаарын байнгын ажиглалт хийх мэргэжлийн сургалтанд хамрагдсан байна; 2/ нарийвчлалыг нь эрх бүхий газраар баталгаажуулсан зориулалтын хэмжих хэрэгсэл, эсхүл харьцуулалт хийх систем ашиглана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>174.7. <u>Гэрчилгээ эзэмших хүсэлт</u> гаргах <u>НЦУУБ</u>-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24174/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт <u>Даргад</u> хүргүүлнэ:</p> <p>(1) 174.79-д шаардсан <u>Ерөнхий</u> заавар; (2) зохих төлбөрийн баримт.</p>	<p>174.7 <u>Өргөдөл</u> гаргах</p> <p>(a) Нисэхийн цаг уурын байгууллагын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч (цаашид Өргөдөл гаргагч гэх) нь ИНЕГ-174/ 01 маягтыг бөглөн дараах бичиг баримтын хамт <u>ИНЕГ</u>-т ирүүлнэ: 1/ энэ дүрмийн 174.79-д заасан <u>Үйл ажиллагааны</u> заавар; 2/ төлбөрийн баримт.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
	<p><u>174.9 Гэрчилгээ олгоход тавигдах шаардлага</u> <u>(a) ИНЕГ-аас дараах шаардлагыг хангасан Өргөдөл гаргагчид Цаг уурын байгууллагын гэрчилгээ олгоно:</u></p> <p><u>1/ энэ дүрмийн Б бүлгийн шаардлагыг хангасан;</u> <u>2/ өргөдөл гаргагч болон түүний удирдах албан тушаалтан нь энэ дүрмийн 174.51-ийн (a)-гийн 1/, 2/-т заасан шаардлагыг хангасан.</u></p>	
<p>174.9. <u>Гэрчилгээ олгох</u> <u>Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь НЦУУБ-ын гэрчилгээ эзэмших эрхтэй:</u></p> <p>(1) <u>хүсэлт гаргагч В Бүлгийн шаардлага хангасан байх;</u> (2) <u>хүсэлт гаргагч болон 174.51(a)(1) (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүн байх;</u> (3) <u>тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.</u></p>		<p>- Amend.1-ээр нэмэгдсэн</p>
<p>174.11. <u>Гэрчилгээ эзэмшигчийн эрх</u></p> <p>(a) <u>НЦУУБ</u>-ын гэрчилгээнд тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгогдсон тоног төхөөрөмжийн төрлийг заана.</p> <p>(b) Энэ Дүрмийн 174.107-г харгалзан, <u>НЦУУБ</u>-ын гэрчилгээ эзэмшигч нь цаг уурын үйлчилгээ, цаг уурын үйлчилгээнд ашигладаг цаг уурын мэдээлэл бүрийг болон цаг уурын үйлчилгээнд хамрагдах газар нутаг, агаарын зайг <u>Ерөнхий</u> заавартаа заасан бол тухайн гэрчилгээнд заасан цаг уурын үйлчилгээг үзүүлж болно.</p>	<p>174.11 <u>Гэрчилгээ эзэмшигчийн эрх</u></p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь Үйл ажиллагааны зааварт тодорхойлсон тоног төхөөрөмжийг үйл ажиллагаандаа ашиглана.</p> <p>(б) Энэ дүрмийн 174.107-ыг харгалзан үзсэнээр, Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд зөвшөөрсөн цаг уурын үйлчилгээг <u>Үйл ажиллагааны</u> заавартаа тусгагдсан агаарын зайн тодорхой хэсэг болон талбайд үзүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>174.13. <u>Гэрчилгээний хугацаа</u> (a) <u>НЦУУБ</u>-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл</p>	<p>174.13 <u>Гэрчилгээний хүчинтэй хугацаа</u> (a) Гэрчилгээг 5 хүртэл жилийн хугацаагаар олгох буюу</p>	<p>-Amend.2-оор хүчингүй болсон</p>

<p>сунгаж болно.</p> <p>(b) НЦУУБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.</p> <p>(c) НЦУУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон тохиолдолд Даргад нэн даруй хураалгана.</p> <p>(d) Гэрчилгээг түдгэлзүүлсэн тохиолдолд НЦУУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь зохих баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлнэ.</p>	<p>сунгана.</p> <p>(б) Гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл ИНЕГ-ын эрх бүхий этгээд гэрчилгээний үйлчлэлийг түр түдгэлзүүлснээс болон зөвшөөрлийг цуцлахаас бусад тохиолдолд гэрчилгээ нь хүчин төгөлдөр байна.</p> <p>(в) Гэрчилгээний, эсхүл түр зөвшөөрлийн хугацаа дууссан, эсхүл хүчингүй болгосон тохиолдолд Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээг ИНЕГ-т хураалгана.</p> <p>(г) Илэрсэн зөрчлийн улмаас гэрчилгээний үйлчлэлийг ИНЕГ-ын <u>эрх бүхий этгээд түр түдгэлзүүлсэн тохиолдолд Гэрчилгээ эзэмшигч зөрчлийг арилгасны дараа энэ тухай албан ёсны баталгаа гарган эрх, зөвшөөрөл сэргээлгэх хүсэлтийг тавина.</u></p>	
<p>174.15. Гэрчилгээ сунгах</p> <p>(a) НЦУУБ-ын гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24174/01 маягтын дагуу гаргана.</p> <p>(b) Хүсэлтийг тухайн гэрчилгээнд заасан сунгах хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацааг заагаагүй бол тухайн гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.</p>	<p>174.15 Гэрчилгээний хугацааг сунгах</p> <p>(a) Эзэмшигч нь Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах тухай өргөдлөө ИНЕГ-174/01 маягтын дагуу гаргана.</p> <p>(б) Энэ зүйлийн (a) хэсэгт заасан өргөдлийг гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө ИНЕГ-т ирүүлсэн байна.ИНЕГ-т хандаж болно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
	<p>174.19 Дүрмийн шаардлагаас чөлөөлөх</p> <p>(a) ИНЕГ-ын дарга нь шаардлагатай гэж үзвэл аливаа этгээдийг энэ дүрмийн шаардлагаас ИНД-11-ийн холбогдох заалтыг үндэслэн чөлөөлж болно.</p>	<p>-Amend.3-аар хүчингүй болсон</p>
<p>В Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага</p>	<p>Б БҮЛЭГ. ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>	
<p>174.51. Ажилтанд тавих шаардлага</p> <p>(a) НЦУУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:</p> <p>(1)Ерөнхий заавартаа заасан цаг уурын үйлчилгээ бүрийг санхүүжүүлэх ба энэ Дүрэмд заасан шаардлага болон стандартын дагуу гүйцэтгэж чадахаа хүсэлт гаргагчийн байгууллагын хүрээнд бататгах үүрэгтэй Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон удирдах ажилтан;</p> <p>(2)дараах үйл ажиллагааны чиглэлээр Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх удирдах ажилтан, эсхүл ажилтнууд:</p> <p>(i) хүсэлт гаргагчийн байгууллага нь Ерөнхий заавраа дагаж мөрдөж байгааг бататгах;</p> <p>(ii) 174.77-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын</p>	<p>174.51 Боловсон хүчинд тавигдах шаардлага</p> <p>(a) Өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтан, ажилтантай байна:</p> <p>1/ байгууллагын үйл ажиллагаа нь компанийн Үйл ажиллагааны зааврын дагуу гүйцэтгэгдэж, санхүүжиж байгааг хянах болон энэ дүрмийн заалтын биелэлтэд хяналт тавих эрх үүрэг бүхий удирдах албан тушаалтан;</p> <p>2/ байгууллага нь энэ дүрмийн шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгааг хянах, бататгах үүрэг хүлээсэн байх ба тэдгээр нь удирдах албан тушаалтантай шууд харьцаж илтгэх хариуцлага бүхий албан тушаалтан;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>тогтолцоо;</p> <p>(3) цаг уурын алба болон тоног төхөөрөмжийг төлөвлөх, ажиллуулах, хяналт тавих, үзлэг шалгалт хийх, гэрчилгээжүүлэх болон хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын үйлчилгээг үзүүлэх хангалттай тооны ажилтан.</p> <p>(aa) Энэ зүйлийн (a)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвар, туршлагаа харуулсан байх үүрэгтэй.</p> <p>(b) <u>Хүсэлт гаргагч нь</u> дараах үүрэгтэй:</p> <p>(1) дараах ажиллагааг гүйцэтгэх хүсэлт гаргагчийн эрх бүхий ажилтанд ур чадварын үнэлгээ хийх журмыг тогтоох:</p> <p>(i) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах;</p> <p>(ii) цаг уурын мэдээллийг боловсруулах болон түгээхэд хяналт тавих;</p> <p>(2) эрх бүхий ажилтны ур чадварыг хадгалах журмыг тогтоох;</p> <p>(3) <u>дээрх ажилтанд, түүний эрхийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох.</u></p>	<p>3/ байгууллагын Үйл ажиллагааны зааварт тусгагдсан нисэхийн цаг уурын үйлчилгээг явуулах мэргэжлийн ажилтантай байх.</p> <p>(б) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах журмыг тогтоосон байна:</p> <p>1/ цаг уурын мэдээ боловсруулан үйлчилгээнд гаргах, түүнд хяналт тавих болон үйлчилгээнд ашиглах тоног төхөөрөмжийг ажиллуулах этгээдийн ур чадварыг үнэлэх ба эрх олгох;</p> <p>2/ эрх бүхий этгээдийн мэргэжлийн ур чадварыг хадгалах, ба</p> <p>3/ эрх бүхий этгээдийн эрхийн цар хүрээг тогтоох.</p>	<p>- Amend.1-ээр нэмэгдсэн</p>
<p>174.53. Ажиллалтын <u>талбайд</u> тавих шаардлага <u>НЦУҮБ</u>-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах шаардлагыг бататгах журмыг тогтоосон байна:</p> <p>(1) <u>Ерөнхий</u> заавартаа заасан цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийг:</p> <p>(i) <u>хууль бус, эсхүл аюултай нөлөөллөөс урьдчилан сэргийлэхээр зохион байгуулагдсан ба аюулгүйн</u> хамгаалалтын арга хэмжээний дагуу ажиглалтын талбайд байрлуулж, тохируулсан байх;</p> <p>(ii) үйлчилгээний тасралтгүй байдлыг бататгах зорилгоор тохирсон цахилгаан <u>хангамж</u> болон хэрэгслээр хангасан байх;</p> <p>(2) <u>Ерөнхий</u> заавартаа заасан цаг агаарыг зайнаас тандан <u>мэдрэх</u> тоног төхөөрөмж бүрийг орон нутгийн цаг уурын нөхцөлийг үнэн зөв харуулдаг байхыг бататгах техникийн шаардлага хангасан байршилд суурилуулсан ба засвар үйлчилгээ хийсэн байх.</p>	<p>174.53 Ажлын <u>байранд</u> тавигдах шаардлага</p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах журмыг боловсруулсан байна:</p> <p>1/ <u>үйл ажиллагааны зааварт тусгагдсан ажлын байр болон тоног төхөөрөмжийг гадны аливаа хууль бус халдлагаас сэргийлэх</u> хамгаалалтын болон үйлчилгээг тасралтгүй явуулахад шаардагдах цахилгаан <u>эрчим хүч</u>, бусад <u>хангалтын</u> тухай журам;</p> <p>2/ үйл ажиллагааны зааварт тусгагдсан цаг агаарыг зайнаас тандан судлах тоног төхөөрөмж нь зөв суурилагдсан, техникийн шаардлага хангаж байгаа болон тухайн газар орны цаг уурын нөхцөлийг нарийн тодорхой гаргаж байгааг бататгах тухай журам.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>174.55. Холбооны системийн шаардлага</p> <p>(a) <u>НЦУҮБ</u>-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> Ерөнхий заавартаа заасан цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийг төлөвлөсөн цаг уурын мэдээллээр хангаж чадахыг</p>	<p>174.55 Холбооны системд <u>тавигдах</u> шаардлага</p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны</u> зааварт тусгагдсан цаг уурын үйлчилгээг явуулахад шаардлагатай холбооны системтэй байх ба тэдгээрийн найдвартай ажиллагааг</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>бататгах холбооны систем болон журмыг тогтоосон байна.</p> <p>(b) Холбооны систем болон журам нь дамжуулж байгаа цаг уурын мэдээллийн хэмжээ болон <u>шинж чанарыг дамжуулалтын саатлаас шалтгаалан</u> тухайн цаг уурын мэдээлэл <u>хуучирч хүчингүй болдоггүй байхаар</u> зохицуулах чадвартай байх ёстой.</p>	<p>бататгах журамтай байна.</p> <p>(б) Холбооны систем нь цаг уурын мэдээг цаг тухайд нь хүлээн авах болон <u>дамжуулах боломжтой байх</u> шаардлагыг хангасан байхаар зохион байгуулагдсан байна.</p>	
<p>174.57. Цаг уурын мэдээний өгөгдлийг цуглуулахад тавих шаардлага</p> <p>(a) <u>НЦҮҮБ</u>-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээнд тохирсон цаг уурын оролтын мэдээллийг олж авах журмыг тогтоосон байна.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь дараах шаардлагыг бататгасан байна:</p> <p>(1) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан урьдчилсан мэдээний үйлчилгээ үзүүлдэг цаг уурын алба болон тоног төхөөрөмж нь тухайн хүсэлт гаргагчийн хариуцсан урьдчилсан мэдээний бүсэд</u> олон жилийн дундаж, бодит ажиглалтын болон бусад цаг уурын мэдээллийг байнга <u>ашиглах боломжтой</u> байх;</p> <p>(2) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын зааварчилгаа өгөх үйлчилгээг биечлэн, эсхүл дүрслэн харуулах бусад хэрэгсэл ашиглан үзүүлдэг цаг уурын алба болон тоног төхөөрөмж нь тухайн зааварчилгааг өгөхөд тохирсон дэлгэц болон зааварчилгааны эх үүсвэрийг ашиглах боломжтой</u> байх;</p> <p>(3) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын мэдээний үйлчилгээ үзүүлдэг цаг уурын алба болон тоног төхөөрөмж нь тохирсон, үнэн зөв, цаг уурын мэдээгээр цаг хугацаанд нь хангахад шаардлагатай</u> ажиглалтын системтэй байх;</p> <p>(4) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын ажиглалтын үйлчилгээ үзүүлдэг цаг уурын алба нь тохирсон, үнэн зөв, цаг уурын ажиглалтын үйлчилгээгээр цаг хугацаанд нь хангахад шаардлагатай цаг уурын мэдээлэлтэй</u> байх;</p> <p>(5) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан</u> уур амьсгалын мэдээний үйлчилгээ үзүүлдэг цаг уурын алба болон <u>тоног төхөөрөмж нь</u> уур амьсгалын мэдээ бэлтгэхэд шаардлагатай цаг уурын <u>мэдээлэлтэй</u> байх.</p>	<p>174.57 Мэдээ хүлээн авахад тавигдах шаардлага</p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны зааварт</u> тусгагдсан цаг уурын үйлчилгээг явуулахад шаардагдах мэдээ хүлээн авах журамтай байна.</p> <p>(б) Энэ зүйлийн (a) хэсэгт дурдсан журмаар дараах зүйлийг бататгана:</p> <p>1/ цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчилж байгаа тухайн нутаг дэвсгэрийн олон жилийн дундаж, бодит ажиглалтын болон бусад байнгын мэдээлэлтэй байх;</p> <p>2/ <u>цаг уурын зөвлөмж өгөх үйлчилгээ явуулах тоног төхөөрөмж нь</u> дэлгэцийн болон <u>мэдээллийн бусад идэвхит хэрэгслүүдтэй</u> байх;</p> <p>3/ <u>тогтмол</u>, үнэн зөв, <u>нарийн</u> цаг агаарын мэдээгээр хангахын тулд цаг уурын <u>бодит</u> ажиглалтын системтэй байх;</p> <p>4/ цаг уурын үйлчилгээ бүр нь <u>зөвшөөрөгдөхүйц нарийвчлал бүхий</u> цаг уурын шаардлагатай бүх мэдээний <u>хангалттай</u> байх;</p> <p>5/ уур амьсгалын мэдээллээр үйлчлэхийн тулд <u>5-аас доошгүй жилийн цаг уурын ажиглалтын мэдээний сантай</u> байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>174.59. Цаг уурын мэдээлэл боловсруулан гаргахад</p>	<p>174.59 Мэдээ түгээхэд тавигдах шаардлага</p>	<p>-Amend.2-oor</p>

<p>тавих шаардлага</p> <p>(а) <u>НЦУУБ</u>-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) <u>Ерөнхий</u> заавартаа заасан <u>цаг уурын үйлчилгээ бүрээр хангадаг боловсруулан гаргах цаг уурын мэдээллийг ангилах</u>;</p> <p>(2) <u>боловсруулан гаргах цаг уурын мэдээллийн</u> стандарт болон форматыг <u>тогтоох</u>.</p> <p>(б) <u>Хүсэлт гаргагч нь Ерөнхий</u> заавартаа заасан <u>цаг уурын алба болон байгууламжаас гаргасан цаг уурын мэдээлэл нь</u> энэ зүйлийн (а)(2)-ын дагуу тогтоосон стандарт болон форматад нийцэж байгааг <u>бататгах</u> журмыг тогтоосон байна.</p>	<p>(а) <u>Өргөдөл гаргагч нь:</u></p> <p>1/ <u>Үйл ажиллагааны</u> зааварт <u>тусгагдсан мэдээг түгээх, ба</u></p> <p>2/ <u>түгээж буй мэдээ бүрийн</u> стандарт болон форматыг <u>тодорхойлно</u>.</p> <p>(б) <u>Өргөдөл гаргагч нь түгээгдэж байгаа мэдээ</u> энэ зүйлийн (а)-гийн 2/-т дурдсан стандарт болон форматад нийцэж байгааг <u>хянах</u> журмыг тогтооно.</p>	<p>хүчингүй болсон</p>
<p>174.61. Тоног төхөөрөмжид тавих шаардлага</p> <p><u>НЦУУБ</u>-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> цаг уурын мэдээллийг <u>олж авах, эмхэтгэх, тооцоолох</u>, ашиглах эсхүл түгээхэд хэрэглэдэг цахим өгөгдлийг боловсруулдаг бүх тоног төхөөрөмж нь цаг уурын болон холбогдох мэдээллийн таарц, нарийвчлал болон тухайн цаг хугацаандаа тохирсон болохыг <u>бататгах шинж чанар, бүтэц болон хүчин чадалтай болохыг</u> бататгах журмыг тогтоосон байна.</p>	<p>174.61 Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага</p> <p>(а) <u>Өргөдөл гаргагч нь</u> цаг уурын болон бусад холбогдох мэдээг <u>цуглуулах, харьцуулан дүгнэх, үнэлэх</u>, түгээхэд ашигладаг цахим төхөөрөмжийн мэдээллийг үнэн зөв гаргаж, цаг тухайд нь хангалт хийх чадвартай эсэхэд хяналт тавих журамтай байна.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>174.63. Баримт бичиг</p> <p>(а) <u>НЦУУБ</u>-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий</u> заавартаа <u>заасан</u> цаг уурын үйлчилгээг <u>үзүүлэхэд</u> шаардагдах цаг уурын албаны журам, <u>тоног төхөөрөмжийн заавар</u>, техникийн <u>стандарт болон зөвлөмж, үйл ажиллагааны заавар</u>, бусад баримт бичгийн хувийг хадгална.</p> <p>(б) <u>Хүсэлт гаргагч нь</u> энэ зүйлийн (а)-д шаардсан баримт бичгийг хянах журмыг тогтоосон байна. Энэ журам нь дараах шаардлагыг бататгасан байна:</p> <p>(1) тухайн баримт бичгийг боловсруулж <u>гаргахаас</u> өмнө <u>холбогдох ажилтан</u> хянаж, зөвшөөрдөг байх;</p> <p>(2) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай холбогдох бүх баримт бичгийн хүчинтэй хувийг тухайн баримт бичиг шаардлагатай бүх <u>байрлалд ажилтан авч ашиглахад бэлэн байлгах</u>;</p> <p>(3) <u>хүчингүй болсон</u> баримт бичгийг боловсруулж гаргасан, эсхүл ашиглаж байгаа цэг бүрээс <u>нэн даруй</u> хураан авдаг байх;</p> <p>(4) тухайн баримт бичгийн өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;</p>	<p>174.63 Бичиг баримт</p> <p>(а) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны</u> зааварт <u>тусгагдсан</u> цаг уурын үйлчилгээг <u>явуулахад</u> шаардагдах заавар, журам, <u>тоног төхөөрөмжийн гарын авлага</u>, техникийн <u>ашиглалтын зааварчилга</u> болон бусад бичиг баримтын хувийг хадгална.</p> <p>(б) <u>Өргөдөл гаргагч нь</u> энэ зүйлийн (а) хэсэгт дурдсан бичиг баримтыг хянах журамтай байх ба журмаар дараах зүйлийг бататгана:</p> <p>1/ бичиг баримтыг хэвлэн <u>түгээхээс</u> өмнө нисэхийн цаг уурын байгууллагын <u>удирдах албан тушаалтан</u> хянаж зөвшөөрсөн байх;</p> <p>2/ хүчин төгөлдөр бичиг баримт нь <u>шаардлагатай этгээдэд хүргэгдсэн байх</u>;</p> <p>3/ <u>ашиглалтаас хасагдсан</u> бичиг баримтыг <u>цаг тухайд нь</u> хураан авсан байх;</p> <p>4/ бичиг баримтанд хийгдсэн өөрчлөлт нь холбогдох албан тушаалтнаар хянагдаж зөвшөөрөгдсөн байх, ба</p> <p>5/ бичиг баримтын хүчин төгөлдөр хувь бүрд <u>хүчингүй</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>(5) <u>хугацаа нь дууссан</u> хэвлэлтийг ашиглахаас сэргийлж баримт бичгийн <u>хуудас бүрийн хүчинтэй хувийг таньж тогтоож болдог</u> байх.</p>	<p><u>болсон буюу өөрчлөлт орсон хэсгийг зааж тэмдэглэсэн</u> байх.</p>	
<p>174.65. <u>Бататгах, хугацаат үзлэг шалгалт тест болон тохируулга хийх</u> (a) <u>НЦҮҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах журмыг тогтоосон байна: (1) <u>хүсэлт гаргагч цуглуулсан болон түгээж байгаа</u> цаг уурын мэдээллийг байнга <u>бататгадаг</u> байх; (2) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын алба бүрд хугацаат</u> үзлэг шалгалт хийдэг байх; (3) <u>хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан тоног төхөөрөмж бүрд хугацаат</u> үзлэг шалгалт <u>тест</u> болон тохируулга хийдэг байх. (b) Энэ зүйлийн (а)-д заасан журам нь дараах шаардлагыг бататгасан байна: (1) цаг уурын мэдээллийг байнга <u>бататгахад</u> шаардлагатай тогтолцоо нь тухайн цаг уурын мэдээллийг бататгахад шаардлагатай <u>чадалтай ба бүрэн ажилладаг</u> байх; (2) цаг уурын алба бүрд үзлэг шалгалт хийхэд шаардлагатай үзлэг шалгалтын төхөөрөмж ёиётемийг ажилтан авч ашиглахад бэлэн байлгах; (3) холбогдох үзлэг шалгалт хэмжилт болон тестийн төхөөрөмж, систем нь тоног төхөөрөмжийн үзлэг шалгалт тест болон тохируулга хийх ажилтан авч ашиглахад бэлэн байх; (4) үзлэг шалгалт хэмжилт болон тестийн төхөөрөмж, систем нь тухайн хийж байгаа үзлэг, хэмжилт болон тестэд шаардлагатай оновчтой ба нарийвчлалтай байх; (5) <u>иж бүрдэлд орсон, эсхүл нэмж суурилүүлсан хүрээлэн буй орчныг тандах мэдрүүр нь аль болох боломжит байдлаар найдвартай, үнэн зөв ба төлөөлөхүйц цаг уурын мэдээлэл өгдөг байхаар бүх цаг уурын тандан мэдрэх тоног төхөөрөмжид тохируулга хийж, ажлын горимд оруулсан байх.</u></p>	<p>174.65 <u>Үечилсэн үзлэг, шалгалт, туршилт ба тохируулга</u> (a) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах журмыг боловсруулсан байна: 1/ цаг уурын мэдээ бүрийг байнга <u>шалгах</u>; 2/ <u>цаг уурын үйлчилгээ үзүүлж байгаа нэгж салбарт үечилсэн</u> үзлэг хийх; 3/ <u>цаг уурын үйлчилгээнд ашиглаж байгаа тоног төхөөрөмж бүрт үечилсэн</u> үзлэг, <u>шалгалт, туршилт</u>, тохируулга хийх. (b) Энэ зүйлийн (а) хэсэгт заасан журмаар дараах зүйлийг бататгана: 1/ цаг уурын мэдээг байнга <u>шалгах</u> систем нь мэдээг шалгахын тулд түүнийг <u>нэгдмэл</u>, цогц байдлаар шалгах чадвартай; 2/ шалгалт, хэмжилт, тохируулга хийх багаж хэрэгсэл болон систем нь тоног төхөөрөмж бүрийн шалгалт, тохируулгад ашиглахад бэлэн байх; 3/ шалгалт, хэмжилт, тохируулга хийх багаж хэрэгсэл, систем нь зөвшөөрөгдөхүйц нарийвчлал бүхий тохируулгатай; 4/ цаг уурын ажиглалтын мэдрэмтгий тоног төхөөрөмж нь найдвартай зөв суурилагдсан, тохируулагдсан байх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>174.67. <u>Цаг уурын мэдээлэл гаргах</u> (a) <u>НЦҮҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах журмыг тогтоосон байна: (1) <u>Ерөнхий заавартаа заасан</u> цаг уурын алба бүрээс цаг уурын мэдээлэл гаргах; (2) <u>Ерөнхий заавартаа заасан тоног төхөөрөмжийг</u> үйл</p>	<p>174.67 <u>Цаг уурын мэдээ гаргах</u> (a) <u>Өргөдөл гаргагч нь</u> дараах журмыг боловсруулж мөрдөнө: 1/ цаг уурын мэдээг <u>боловсруулан</u> үйлчилгээнд гаргах; 2/ <u>тоног төхөөрөмжийг</u> үйлчилгээнд ашиглах;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>ажиллагаанд оруулах;</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь үйл ажиллагааг хянах, цаг уурын мэдээллийг гаргах эрх бүхий этгээд болон цаг уурын тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах эрх бүхий этгээдийг 174.51(b)-д шаардсан журмын дагуу ур чадвартай болохыг үнэлгээ хийж бататгадаг байна.</p>	<p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан журамд, цаг уурын мэдээг үйлчилгээнд гаргах болон цаг уурын тоног төхөөрөмжийг үйлчилгээнд бэлэн байлгах этгээд нь энэ дүрмийн 174.51-ийн (б)-д заагдсан журмын дагуу эрх олгогдсон гэдгийг бататгана.</p>	
<p>174.69. Цаг уурын алба болон тоног төхөөрөмжийн төлөв байдлыг мэдээлэх</p> <p>(a) <u>НЦҮҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан цаг уурын алба, эсхүл тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны төлөв байдлын өөрчлөлт болон холбогдох үйл ажиллагааны мэдээллийг тухайн цаг уурын үйлчилгээг хэрэглэгчдэд мэдээлэх журмыг тогтоосон байх үүрэгтэй.</u></p> <p>(b) Хүсэлт гаргагч энэ зүйлийн (a)-ийн дагуу тогтоосон журам нь дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:</p> <p>(1) Монгол Улсын агаарын навигацийн систем, эсхүл НХҮ-г дэмждэг хүсэлт гаргагчийн цаг уурын үйлчилгээ бүрийн үйл ажиллагааны мэдээллийг Монгол Улсын AIP-д хэвлэн нийтлүүлэх зорилгоор НМҮ-ний байгууллагад хүргүүлдэг байх;</p> <p>(2) хэрэв тухайн өөрчлөлт нь агаарын навигацийн аюулгүй байдалд нөлөөлж болох бол, цаг уурын алба, эсхүл <u>тоног төхөөрөмжийн хэрэглэгчдэд цаг уурын алба, эсхүл тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны төлөв байдлын аливаа өөрчлөлтийг нэн даруй мэдээлдэг байх. Монгол Улсын AIP-д хэвлэн нийтэлсэн цаг уурын алба болон байгууламжийн хувьд, тэдгээрийн үйл ажиллагааны төлөв байдлын аливаа өөрчлөлттэй холбоотой мэдээллийг NOTAM-аар гаргахаар НМҮ-ний байгууллагад заавал хүргүүлдэг байх.</u></p>	<p>174.69 <u>Үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн талаар мэдээлэх</u></p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь өөрийн үйл ажиллагаанд болон тоног төхөөрөмжид гарсан аливаа өөрчлөлтийн талаар хэрэглэгчдэд мэдээлэх журмыг тогтооно.</u></p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан журамд:</p> <p>1/ Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх иргэний нислэг, нислэгийн хөдөлгөөний удирдлагад ашиглагдах үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх аливаа мэдээ, мэдээллийг Монгол Улсын Агаарын навигацийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д нийтлүүлэхээр <u>ИНЕГ</u>-т ирүүлж байх тухай,</p> <p>2/ <u>Үйл ажиллагааны заавартаа орсон тоног төхөөрөмжийн ажиллагаанд гарсан аливаа өөрчлөлт нь нислэгийн аюулгүй ажиллагаанд харшлахаар</u> бол өөрийн хэрэглэгчид болон NOTAM-ын албанд <u>нэн даруй</u> мэдэгдэж байх тухай тус тус тусгана.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.2-оор нэмэгдсэн</p>
<p>174.71. Осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах</p> <p>(a) <u>НЦҮҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> осол, эсхүл зөрчилд өртсөн агаарын хөлөг, эсхүл НХҮ-нд ашигласан байж болох өөрийн түгээсэн цаг уурын мэдээллийн таарц, нарийвчлал болон тухайн цаг хугацаандаа тохирсон болохыг шалгах журмыг тогтоосон байна.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь дараах шаардлагыг бататгасан байна:</p> <p>(1) осол, эсхүл зөрчлийг хүсэлт гаргагчийн байгууллагад</p>	<p>174.71 <u>Нислэг-техникийн осол, зөрчлийн дараа цаг уурын мэдээг шалгах</u></p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь</u> осол, зөрчилд холбогдсон агаарын хөлөг болон нислэгийн хөдөлгөөнийг удирдах үйл ажиллагаанд ашигласан байж болох цаг уурын бүх мэдээ үнэн зөв, цаг хугацааны хувьд тохирч байсан эсэхийг шалгах журам боловсруулсан байна.</p> <p>(б) Энэ зүйлийн (a)-д заасан журамд дараах зүйлийг бататгасан байна:</p> <p>1/ осол, зөрчил гарсан тухай цаг уурын байгууллагад мэдэгдсэний дараа нэн даруй нягтлан шалгах;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>мэдэгдсэний дараа шалгалтыг нэн даруй гүйцэтгэх; (2) цаг уурын мэдээллийн хувийг дараагийн шинжлэн шалгах ажиллагаанд ашиглахад боломжтой байлгах зорилгоор аюулгүй газар хадгалах.</p>	<p>2/ цаг уурын мэдээний хувийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд ашиглахад бэлэн байлгах зорилгоор найдвартай газар хадгалах.</p>	
<p>174.73. Тоног төхөөрөмжийн <u>доголдол</u> болон алдаатай <u>мэдээлэл</u> <u>НЦУҮБ</u>-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь</u> дараах журмыг тогтоосон байна:</p> <ol style="list-style-type: none"> (1) алдаатай цаг уурын мэдээллийг таньж тогтоох бүртгэх, мэдэгдэх, шинжлэн шалгах болон залруулах; (2) алдаатай цаг уурын мэдээллээр хангахад хүргэж болох, Ерөнхий заавартаа заасан тоног төхөөрөмж болон цаг уурын үйлчилгээнд илэрсэн доголдлыг таньж тогтоох бүртгэх, мэдээлэх, шинжлэн шалгах болон залруулах; (3) алдаатай цаг уурын мэдээллийг хүлээн авсан бүх хэрэглэгчдэд цаг алдалгүй мэдэгдэх; (4) 72 цагийн дотор засаж залруулж чадахгүй тоног төхөөрөмжийн доголдлыг 12 цагийн дотор <u>Даргад</u> мэдэгдэх; (5) Дарга шаардсан тохиолдолд, тухайн тоног төхөөрөмжийн доголдлын төлөв байдлын үргэлжлэлийг мэдээлэх. 	<p>174.73 Алдаатай буюу <u>ташаа мэдээ</u> (a) Өргөдөл гаргагч нь дараах зүйлийг хамарсан журам тогтооно:</p> <ol style="list-style-type: none"> 1/ ташаа мэдээг олж тогтоох, бичлэг хийх, мэдэгдэх, шинжлэн шалгах болон алдааг залруулах; 2/ ташаа мэдээ гаргах болсон шалтгаан нь цаг уурын үйлчилгээ, тоног төхөөрөмжид илэрсэн дутагдлаас болсон эсэхийг тогтоох, бичлэг хийх, мэдэгдэх, шинжлэн шалгах болон алдааг засах; 3/ цаг уурын ташаа мэдээ түгээгдсэн тухай хэрэглэгчдэд нэн даруй мэдэгдэх; 4/ 72 цагийн дотор засаж залруулах боломжгүй ташаа мэдээ, үйл ажиллагааны тухай <u>ИНЕГ</u>-ын эрх бүхий этгээдэд 12 цагийн дотор мэдэгдэх; 5/ алдаатай гэж үзсэн зарим мэдээг цаашид үргэлжлүүлэн гаргах эсэхийг 	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>174.75. <u>Бүртгэл</u></p> <p>(a) <u>НЦУҮБ</u>-ын <u>гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа</u> заасан цаг уурын үйлчилгээгээр хангахад шаардлагатай бүртгэлийг <u>таньж тогтоох</u>, цуглуулах, <u>индексжүүлэх</u>, хадгалах, <u>хөтлөх болон үстгах</u> журмыг тогтоосон байх үүрэгтэй.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь дараах шаардлагыг бататгах ёстой:</p> <ol style="list-style-type: none"> (1) 174.57-д шаардсан журмын дагуу <u>цуглуулсан</u> цаг уурын <u>мэдээний өгөгдлийн бүртгэлтэй</u> байх; (2) 174.59-ийн дагуу <u>тогтоосон, бүх боловсруулан гаргасан</u> цаг уурын мэдээллийн бүртгэлтэй байх; (3) энэ зүйлийн (b)(1) болон (2)-т заасан бүртгэлийг 60-аас доошгүй хоног, эсхүл <u>Даргын</u> шаардаж болох хугацаагаар хадгалдаг байх; (4) <u>цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийн гүйцэтгэлийг баримтжуулах түүний техник үйлчилгээ, үйлчилгээ болон бүтээгдэхүүний чанар, хугацаат үзлэг шалгалт болон эдгээр ажиллагаа түс бүрийг хариуцсан ажилтны түүхийг эргэн тогтоох боломжоор хангах</u> 	<p>174.75 <u>Цаг уурын мэдээний бичлэг</u></p> <p>(a) <u>Өргөдөл гаргагч нь</u> өөрийн эрхлэх цаг уурын үйлчилгээнд шаардагдах мэдээний бичлэгийг <u>олж тогтоох</u>, цуглуулах, ангилах, архивлах, хадгалах, <u>хэрэглээнээс гаргах</u> журмыг тогтоох үүрэгтэй.</p> <p>(b) Энэ зүйлийн (a)-д заасан журамд дараах бичлэгүүд багтана:</p> <ol style="list-style-type: none"> 1/ энэ дүрмийн 174.57-ийн дагуу <u>хүлээн авсан</u> цаг уурын мэдээний бичлэг; 2/ энэ дүрмийн 174.59-ын дагуу хэрэглэгчдэд <u>түгээсэн</u> цаг уурын бүх мэдээний бичлэг; 3/ 60 хүртэл хоногийн хугацаагаар хадгалах, энэ хэсгийн 1/, 2/-т дурдсан бичлэгүүд; 4/ <u>өргөдөл гаргагчаас олгосон эрхийн дагуу нислэгийн мэдээллийг шалгах, хэвлэн гаргах ажлыг хариуцсан этгээдийн талаар хийсэн бичлэг;</u> 	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.4-өөр нэмэгдсэн</p>

<p><u>зорилгоор хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийн бүртгэлтэй байх.</u></p> <p>(5) <u>174.65-д шаардсан журмын дагуу бататгах, үзлэг шалгалт, тест болон тохируулга хийхэд ашигладаг төхөөрөмж болон системийн бүртгэлтэй байх. Бүртгэл нь тухайн төхөөрөмж болон системийн байрлал, техник үйлчилгээ тохируулгын шалгалтын түүхийг эргэн тогтоох боломжоор хангах ёстой;</u></p> <p>(6) <u>174.73-т шаардсан журмын дагуу мэдээлсэн алдаатай цаг уурын мэдээлэл болон илрүүлсэн тоног төхөөрөмжийн доголдол бүрийн бүртгэлтэй байх. Бүртгэл нь алдаатай цаг уурын мэдээлэл, эсхүл тоног төхөөрөмжийн доголдол болон шинжлэн шалгах ажиллагааны үед илрүүлсэн дутагдлын шинж чанар залруулах арга хэмжээг эргэн шалгах талаар дэлгэрэнгүй заасан байх ёстой;</u></p> <p>(7) [хүчингүй]</p> <p>(8) <u>хүсэлт гаргагчийн цаг уурын мэдээллийг боловсруулах болон түгээхэд хяналт тавих тухайн тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах эрх бүхий этгээдийн бүртгэлтэй байх. Бүртгэл нь тэдгээрийн ажлын түршлага, мэргэшил, сургалт, олгосон эрхийн мэдээллийг багтаах ёстой;</u></p> <p>(9) <u>бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд байнгын, арилдаггүй хэлбэртэй байх;</u></p> <p>(10) <u>энэ зүйлийн (б)(1) болон (2)-т шаардсанаас бусад бүх бүртгэлийг 1 жилээс доошгүй хугацаагаар, эсхүл цаг уурын үйлчилгээний гүйцэтгэлийн түүхийг үүсгэх зорилгоор Даргын шаардаж болох хугацаагаар хадгалдаг байх.</u></p>	<p>5/ <u>ташаа мэдээ гаргасан багаж хэрэгсэл, системийн засвар үйлчилгээ, тохируулгыг хийхэд</u> энэ дүрмийн 174.65-ын дагуу ашигласан тоног төхөөрөмжийн бичлэг;</p> <p>6/ <u>энэ дүрмийн 174.77-т заасан чанарын дотоодын хяналтын талаарх дүгнэлтийн бичлэгүүд.</u></p> <p>(в) Энэ зүйлийн (б)-гийн 1/, 2/-т дурдсанаас бусад бүх бичлэгийг 1 жил, түүнээс дээш хугацаагаар хадгална.</p>	
<p>174.77. Аюулгүй байдлын удирдлага <u>НЦУУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.</u></p>	<p>174.77 Чанарын дотоод хяналт <u>(а) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн шаардлагын дагуу үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, түүнд нийцүүлэн ажиллах Чанарын дотоодын хяналтын журмыг тогтооно.</u> <u>(б) Чанарын дотоод хяналт хариуцсан албан тушаалтан нь цаг уурын мэдээний чанар, нийцэл, үйл ажиллагааны журмын биелэлт зэрэг асуудлаар байгууллагын удирдах албан тушаалтантай шууд харьцана.</u></p>	<p>- Amend.4-өөр нэмэгдсэн</p>
<p>174.79. НЦУУБ-ын Ерөнхий заавар (а) <u>НЦУУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:</u> (1) <u>Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад заавар нь дараах шаардлагыг хангасан болохыг бататган,</u></p>	<p>174.79 Үйл ажиллагааны зааварт тавигдах шаардлага (а) <u>Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны заавартаа дараах зүйлийг тусгасан байна:</u> 1/ <u>өргөдөл гаргагчийн удирдах албан тушаалтан нь:</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан - Amend.4-өөр нэмэгдсэн</p>

хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:

- (i) тухайн байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулсан байх;
 - (ii) хүсэлт гаргагчийн байгууллагын ажилтнууд түүнийг байнга дагаж мөрддөг байх;
- (1A) 174.77-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:
- (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) НЦУУБ-ын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 174.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал, нэр;
- (3) 174.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын дараах үүрэг, хариуцлага:
- (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
 - (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;
- (4) 174.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (5) энэ зүйлийн (a)(7)(i)-д заасан цаг уурын албанд ажиллах тухайн байгууллагын ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (5A) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
- (6) гэрчилгээнд тусгагдсан цаг уурын үйлчилгээний жагсаалт;
- (7) дараах мэдээлэл бүхий жагсаалт:
- (i) хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа цаг уурын алба бүрийн байрлал;
 - (ii) хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, хэрэглэгчийг цаг уурын мэдээллээр шууд хангадаг тоног төхөөрөмж бүрийн байрлал;
 - (iii) эдгээр цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийн үзүүлдэг цаг уурын үйлчилгээ;

1.1 энэ дүрэм болон бусад дүрмийн заалтыг дагаж мөрдөж буйг бататгах арга хэрэгслийг тодорхойлно;

1.2 зааврыг ажиллагсад байнга дагаж мөрдөхийг шаардана.

2/ энэ дүрмийн 174.51-ийн (a)-гийн 1/, 2/-т заагдсан албан тушаалтнуудын нэрс болон албан тушаал;

3/ энэ зүйлийн 2/-т дурдсан албан тушаалтны хүлээсэн үүрэг хариуцлагатайгаа холбогдсон асуудлаар байгууллагын нэрийн өмнөөс ИНЕГ-тай шууд харьцах эрх олгогдсон тухай;

4/ энэ зүйлийн 2/-т дурьдсан албан тушаалтны үүрэг хариуцлагыг харуулсан бүтэц зохион байгуулалтын бүдүүвч зураглал;

5/ энэ зүйлийн 7/-д заасан бүтцийн схем;

6/ гэрчилгээнд тусгагдсан цаг уурын үйлчилгээ, тэдгээрийн жагсаалт;

7/ цаг уурын нэгж салбар бүрийн хувьд салбар байгууллага, тоног төхөөрөмжийн байрлал болон харьяалах нутаг дэвсгэрийн хил, салбар бүрийн эрхлэх үйлчилгээний жагсаалт;

-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан

<p>(iv) <u>эдгээр цаг уурын үйлчилгээнд хамрагддаг нутаг дэвсгэр болон агаарын зай;</u></p> <p>(8) 174.59(a)(1)-ийн дагуу ангилсан, хүсэлт гаргагчийн боловсруулан гаргасан цаг уурын мэдээллийн дэлгэрэнгүй болон 174.59(a)(2)-ын дагуу тогтоосон мэдээллийн стандарт болон формат;</p> <p>(9) дараах зүйлд шаардсан <u>хүсэлт гаргагчийн журам болон тогтолцооны дэлгэрэнгүй</u> мэдээлэл:</p> <p>(i) <u>174.51(b) - ажилтны үр чадвар;</u></p> <p>(ii) <u>174.53 - ажиглалтын талбайд тавих шаардлага;</u></p> <p>(iii) <u>174.55 - холбооны системийн шаардлага;</u></p> <p>(iv) <u>174.57 - цаг уурын мэдээний өгөгдөл цуглуулахад тавих шаардлага;</u></p> <p>(v) <u>174.59 - цаг уурын мэдээлэл боловсруулан гаргахад тавих шаардлага;</u></p> <p>(vi) <u>174.61 – тоног төхөөрөмжил тавих шаардлага;</u></p> <p>(vii) <u>174.63(b) - баримт бичгийг хянах;</u></p> <p>(viii) <u>174.65 - бататгах, хугацаат үзлэг шалгалт тест болон тохируулга хийх;</u></p> <p>(ix) <u>174.67 - цаг уурын мэдээлэл гаргах ба тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах;</u></p> <p>(x) <u>174.69 - цаг уурын алба болон тоног төхөөрөмжийн төлөв байдлыг мэдэгдэх;</u></p> <p>(xi) <u>174.71 - осол, эсхүл зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах;</u></p> <p>(xii) <u>174.73 – тоног төхөөрөмжийн доголдол болон алдаатай мэдээлэл;</u></p> <p>(xiii) <u>174.75 - бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах;</u></p> <p>(10) <u>Ерөнхий</u> зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх <u>журам</u>.</p> <p>(b) <u>Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.</u></p>	<p>8/ энэ дүрмийн 174.59-ын (а)-гийн 1/, 2/-ын дагуу гаргаж, түгээх цаг уурын мэдээ, мэдээний формат, стандартын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;</p> <p>9/ энэ дүрмийн 174.51-ийн (б) - 174.61; 174.63-гийн (б) - 174.77-гийн дагуу шаардагдах мэдээлэл;</p> <p>10/ <u>үйл ажиллагааны</u> зааврыг хянах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, <u>нийтэд</u> түгээх асуудлууд.</p>	
<p>С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага</p>	<p>В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>	
<p>174.101. Байнгын хэрэгжилт <u>НЦУУБ</u>-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>(1) Ерөнхий заавартаа заасан цаг уурын алба бүрд, тухайн</p>		<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>

<p>зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгалдаг байх;</p> <p>(2) Ерөнхий заавартаа дэлгэрэнгүй заасан бүх журам болон тогтолцоог дагаж мөрддөг байх;</p> <p>(3) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглах боломжтой байлгах;</p> <p>(4) энэ Дүрмийн дагуу гэрчилгээжүүлэлтэд тогтоосон В Бүлгийн шаардлага болон стандартыг байнга хангадаг байх;</p> <p>(5) САА24174/01 маягтад шаардсан үйлчилгээ эрхлэх хаяг, утасны эсхүл факсын дугаарын аливаа өөрчлөлтийг тухайн өөрчлөлт орсноос хойш 28 хоногийн дотор Даргад мэдэгддэг байх.</p>		
<p>174.103. Үйл ажиллагааны <u>заавар</u> <u>НЦУУБ</u>-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа заасан цаг уурын алба бүрийг үйл ажиллагааны заавраар хангасан байна. Үйл ажиллагааны заавар нь цаг уурын алба болон холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны болон техник үйлчилгээний журмыг тогтоох ба дараах мэдээллийн жагсаалтыг багтаасан байна:</p> <p>(1) хангаж байгаа цаг уурын мэдээлэл болон үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээ;</p> <p>(2) <u>тоног төхөөрөмжийн</u> үйл ажиллагааны хүлээн зөвшөөрөгдөх <u>минимум</u> үзүүлэлт болон <u>стандарт</u>;</p> <p>(3) шаардлагатай цаг уурын мэдээний <u>минимум</u> өгөгдөл;</p> <p>(4) боловсруулан гаргах цаг уурын мэдээлэл, болон хангаж байгаа цаг уурын үйлчилгээний гүйцэтгэлийн болон чанарын <u>минимум</u> түвшин;</p> <p>(5) энэ хэсгийн (4)-т заасан <u>минимум</u> түвшнийг хэмжихэд шаардлагатай тестийн төхөөрөмж болон систем;</p> <p>(6) цаг уурын мэдээллийг гаргахад заавал мөрдөх шаардлагатай шалгалтын журам.</p>	<p>174.103 Үйл ажиллагааны <u>гарын авлага</u></p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигч нь Үйл ажиллагааны заавартаа тусгагдсан нэгж, салбар бүрийг үйл ажиллагааны гарын авлагаар хангах ба гарын авлагын жагсаалтад дараах журмууд багтсан байна:</p> <p>1/ цаг уурын үйлчилгээ үзүүлэх буюу цаг агаарын мэдээгээр хангах;</p> <p>2/ <u>тоног төхөөрөмжийн</u> хэвийн ажиллагааны үзүүлэлтүүдийг хангах;</p> <p>3/ цаг уурын мэдээг хүлээн авах;</p> <p>4/ цаг уурын мэдээг гадагш дамжуулах;</p> <p>5/ багаж хэрэгсэл болон системүүдийн хэвийн ажиллагааг шалгах;</p> <p>6/ гаргаж байгаа цаг уурын мэдээг <u>нягтлан шалгах</u>.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>
<p>174.105. Хүчингүй</p>	<p>174.105 Нөөц</p>	
<p>174.107. <u>Гэрчилгээ эзэмшигчид тавих</u> хязгаарлалт <u>НЦУУБ</u>-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах үйл ажиллагааг гүйцэтгэхгүй:</p> <p>(1) <u>тухайн цаг уурын мэдээг гаргахад шаардлагатай цаг уурын мэдээний өгөгдөл байхгүй тохиолдолд</u>, цаг уурын мэдээллээр хангах; эсхүл</p> <p>(2) тухайн цаг уурын <u>алба, эсхүл тоног төхөөрөмжийн</u> үйл ажиллагааны үзүүлэлт нь холбогдох шаардлага хангаагүй тохиолдолд, цаг уурын мэдээллээр хангах; эсхүл</p> <p>(3) <u>тухайн цаг уурын мэдээллийн үнэн зөв байдлын хяналтын</u></p>	<p>174.107 <u>Үйл ажиллагааны хязгаарлалт</u></p> <p>(а) Гэрчилгээ эзэмшигчид дараах зүйлийг хориглоно:</p> <p>1/ <u>ашиглах боломжгүй</u> цаг уурын мэдээгээр <u>хэрэглэгчдийг</u> хангах;</p> <p>2/ цаг уурын мэдээ <u>гаргах байгууллагын</u> үйл ажиллагаа болон <u>тоног төхөөрөмж</u> шаардлага хангахгүй үед хангалт хийх;</p> <p>3/ <u>цаг уурын байгууллагын хяналт шинжилгээний тоног</u></p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

<p>тогтолцоо нь бүрэн гүйцэд ажиллаагүй байхтохиолдолд цаг уурын мэдээллээр хангах; эсхүл</p> <p>(4) тухайн цаг уурын мэдээлэлтэй холбоотой шаардлагатай баталгаажуулалт, үзлэг шалгалт тест, эсхүл тохируулгыг гүйцэд хийгээгүй тохиолдолд цаг уурын мэдээллээр хангах; эсхүл</p> <p>(5) тухайн цаг уурын мэдээллийн үнэн зөв байдалд эргэлзэх аливаа шалтгаан байгаа тохиолдолд цаг уурын мэдээллээр хангах.</p>	<p>төхөөрөмжүүд бүрэн хэмжээгээр ажиллахгүй байгаа үед хангалт хийх;</p> <p>4/ цаг уурын мэдээг шалгадаг багаж төхөөрөмжийн шалгалт, тохируулга бүрэн хийгдэж дуусаагүй байхад цаг уурын мэдээний хангалт хийх;</p> <p>5/ хэрэглэгчээс, цаг уурын мэдээний хангалт бүрэн хэмжээгээр хийгдэхгүй байгаа тухай гомдол гаргасан үед цаг уурын мэдээний хангалт хийх</p>	
<p>174.109. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт</p> <p>(a) НЦУУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг тухайн байгууллага болон үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээний тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийдэг болохыг бататгах үүрэгтэй.</p> <p>(b) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгаа ба тухайн зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөж байгааг бататгах үүрэгтэй.</p> <p>(c) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа нэмэлт өөрчлөлт оруулсны дараа тухайн зааврын нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.</p> <p>(d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхийн өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:</p> <p>(1) Гүйцэтгэх захирал;</p> <p>(2) жагсаалтад заасан удирдах ажилтнууд;</p> <p>(3) гэрчилгээ эзэмшигчийн үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээ;</p> <p>(4) гэрчилгээ эзэмшигчийн үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээнд хамрагддаг нутаг дэвсгэр болон агаарын зай;</p> <p>(5) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хэрэв тухайн өөрчлөлт нь бодит өөрчлөлт бол.</p> <p>(e) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл түүнийг хийсний дараа тухайн гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх ёстой нөхцөлийг Дарга тогтоож болно.</p> <p>(f) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e)-гийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.</p> <p>(g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад цаг алдалгүй хүргүүлэх</p>	<p>174.109 Үйл ажиллагааны зааварт өөрчлөлт орох</p> <p>(a) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн Үйл ажиллагааны заавар болон үйлчилгээнийхээ жагсаалтыг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж байх үүрэгтэй.</p> <p>(б) Гэрчилгээ эзэмшигч нь, түүний Үйл ажиллагааны заавар болон үйлчилгээний жагсаалтад орсон аливаа өөрчлөлт энэ дүрмийн шаардлагыг хангаж байхыг хариуцна.</p> <p>(в) Гэрчилгээ эзэмшигч нь өөрийн Үйл ажиллагааны заавар болон үйлчилгээнийхээ жагсаалтад оруулсан өөрчлөлтийг мөрдөж эхлэхийн өмнө ИНЕГ-т мэдэгдэж байна.</p> <p>(г) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг оруулахын өмнө ИНЕГ-т урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсан байна:</p> <p>1/ байгууллагын удирдлага өөрчлөгдөх;</p> <p>2/ жагсаалтад орсон ахлах ажилтнууд өөрчлөгдөх;</p> <p>3/ үйлчилгээний жагсаалтад өөрчлөлт орох;</p> <p>4/ байгууллагын байрлал болон үйлчлэх нутаг дэвсгэрийн хэмжээ өөрчлөгдөх.</p> <p>(д) Энэ зүйлийн (г)-д дурдсан өөрчлөлтүүдийг хийх, эсхүл тэдгээрийг мөрдөх явцад гарах зарим нөхцөлийг ИНЕГ-ын дарга тодорхойлж болно.</p> <p>(e) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (д)-д дурдсан нөхцөлийг мөрдөж ажиллах үүрэгтэй.</p> <p>(ж) Энэ дүрмийн дагуу хийгдэх аливаа өөрчлөлт нь гэрчилгээнд өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа тохиолдолд Гэрчилгээ эзэмшигч гэрчилгээгээ ИНЕГ-т нэн даруй хүргүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>- Amend.4-өөр нэмэгдсэн</p>

<p>үүрэгтэй.</p> <p>(h) Нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж <u>Даргын</u> үзсэн нэмэлт өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч <u>Ерөнхий</u> заавартаа оруулах үүрэгтэй.</p>	<p>(з) Гэрчилгээ эзэмшигч нь нисэхийн аюулгүй ажиллагааны ашиг сонирхлын үүднээс <u>үйлчилгээний жагсаалтад</u> оруулах нь зүйтэй гэж үзсэн тийм өөрчлөлтийг <u>жагсаалтдаа</u> оруулна.</p>	
	<p><u>174.111 Аюулгүй ажиллагааны хяналт шалгалт</u></p> <p>(a) <u>ИНЕГ-ын даргаас шаардлагатай гэж үзвэл Гэрчилгээ эзэмшигчийн ажлын байр, тоног төхөөрөмж, бичиг баримт болон бичлэгт үзлэг шалгалт хийх буюу үзлэг шалгалтад орохыг бичгээр шаардаж болно.</u></p> <p>(б) <u>ИНЕГ-ын даргаас шаардлагатай гэж үзвэл дээрх үзлэг шалгалтад хамаарах мэдээлэл өгөхийг Гэрчилгээ эзэмшигчээс шаардаж болно.</u></p>	<p>- Amend.4-өөр хүчингүй болсон</p>
<p>D Бүлэг - Шилжилтийн зохицуулалт</p>		
<p>174.151. <u>НЦУУБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилт</u></p> <p>(a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:</p> <p>(1) <u>НЦУУБ-ын гэрчилгээ эзэмшигч;</u></p> <p>(2) <u>НЦУУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.</u></p> <p>(b) Энэ зүйлд хамаарах байгууллага нь энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө дараах заалтыг мөрдөхгүй байж болно:</p> <p>(1) 174.51(a)(2)(ii), хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;</p> <p>(2) 174.77, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх болон мөрдөхийн оронд, 174.153-ыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;</p> <p>(3) 174.79(a)(1A)(i);</p> <p>(4) 174.79(a)(3)(ii);</p> <p>(5) 174.79(a)(5A).</p> <p>(c) <u>НЦУУБ-ын гэрчилгээ эзэмшигч болон НЦУУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг 2020 оны 2 сарын 1-нээс өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.</u></p> <p>(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:</p> <p>(1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон хугацааг багтаасан байх;</p> <p>(2) тухайн байгууллага 174.77-д шаардсан аюулгүй байдлын</p>		<p>- Amend.5-аар нэмэгдсэн</p>

<p>удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.</p> <p>(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол Дарга:</p> <p>(1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;</p> <p>(2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн хугацааг тогтооно.</p> <p>(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хугацааг тогтоохдоо Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:</p> <p>(1) тухайн байгууллагын хүчин чадал;</p> <p>(2) тухайн байгууллагын төвөгшил;</p> <p>(3) тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;</p> <p>(4) гэрчилгээг сунгах хугацаа;</p> <p>(5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;</p> <p>(6) хэрэгжүүлэлтийн хугацаа нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.</p> <p>(g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу <u>НЦУҮБ</u>-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргахгүй байж болно.</p> <p>(h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.</p>		
<p>174.153. <u>НЦУҮБ</u>-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт</p> <p>(a) Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор 174.151(b)(1)(ii)-т шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх ёстой.</p> <p>(b) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь цаг уурын мэдээллийн таарц, нарийвчлал болон тухайн цаг хугацаандаа тохирсон байх шаардлагад нөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцах эрхтэй байна.</p> <p>(c) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.</p>		<p>- Amend.4-өөр нэмэгдсэн</p>